ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.12.05

| № | Заалт | Хэрэгжилт |
|---|---|---|
| | | **Нэг: Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн** |
| 1. | Монгол улсын тогтвортой хөгжил үзэл баримтлал-2030"-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл | **Зорилт 1:Халдварт бус өвчнийг бууруулах зорилгоор иргэдийг урьдчилан сэргийлэх шинжилгээ, оношилгоонд үнэ төлбөргүй хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулах зорилтийн хүрээнд**<br><br>ЭМТ-ийн нарийн мэргэжлийн кабинетууд болон ӨЭМТ –үүд Артерийн даралт, чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 40-60 насны иргэдийг эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ оношлогоонд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан Үүнд:<br><br>• Артерийн гипертензи эрт илрүүлэгийн анхны үзлэгт 32822 /85.4%/ **,**Давтан үзлэгт4148 хүнийг тус тус хамруулж шинээр артерийн даралттай 150 хүнийг илрүүлэн оношилж хяналтандаа авсан.<br>• Чихрийн шижин хэв шинж 2 эрт илрүүлэгийн анхны үзлэг шинжилгээнд 27404 /71.3%/,Давтан үзлэг шинжилгээнд 2260 хүнийг тус тамруулж чихрийн шижинтэй 27хүнийг шинээр оношилж хяналтандаа авч эмчилгээнд хамруулсан.Артерийн даралт илрүүлгийн УБхотын дундаж 56,6%,ЧШ-ийн илрүүлгийн УБ-н дундаж 50.9% тай байгаа бөгөөд ХУЭМТ-д артерийн даралт илрүүлэгт үзлэг хотын дунджаас 25%-иар их,Чихрийн шижингийн илрүүлэгт үзлэг хотын дунджаас 17%-иар өндөр байна.<br><br>Халдварт бус өвчнийг эрт илрүүлэх, оношлох чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор ЭМТ, ӨЭМТөвүүд эрт илрүүлэг үзлэг шинжилгээг эрчимжүүлэх зорилгоор нийт 68 удаагийн аян, 60 удаагийн өдөрлөг, 39 удаагийн тэмдэглэлт өдрийг зохион байгуулан явууллаа..Үүнд:<br>**1.**Эрүүл зүрх-Эрүүл Улаанбаатар" төслийн хүрээнд 2018 оны 05 дугаар сард Артерийн гипертензийн оношилгоо, эмчилгээ, амьдралын хэв маягыг өөрчлөх сэдэвт 3 удаагийн сургалтад дүүргийн 4,5,6,7,8,9,10,11,12,13,14,16 дугаар хороодын эмч, сувилагч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан нар бүрэн хамрагдсан. Сургалт дөрвөн 7 хоногийн хугацаанд нийт 98 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан бөгөөд сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг даралтын аппаратаар бүрэн хангасан. Өрхийн эрүүл мэндийн төвд шинээр ажилд орсон 26 эмчид 10 дугаар сард Артерийн гипертензийн оношилгоо, эмчилгээний давтан сургалтыг зохион байгуулж, АГ-ын шинэ удирдамжийг танилцуулсан. |





**2.**Нийслэлийн Засаг даргын Эрүүл иргэн" аян зохион байгуулах тухай А/567 тоот захирамж, НЭМГ-ын даргын Аян зохион байгуулах тухай 2/612 тоот албан тоотын хүрээнд ЭМТ-ийн даргын "Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах тухай" А/80 тоот тушаалаар үзлэгийн хуваарийг баталсан. Уг тушаалаар хуваарийн дагуу 15 хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйлчлэх хүрээний 1301 хүн амд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг хийж, 169 иргэн өвчтэй илэрснийг эмчилгээнд хамруулж эрүүлжүүлсэн. "Эрүүл иргэн" аяны нээлтийг 2018 оны 6 сарын 21 өдөр дүүргийн 16 дугаар хорооны Энхбуянт манал өрхийн эрүүл мэндийн төвд зохион байгуулж нээлтэнд 120 гаруй хүн ирж оролцсон . Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд ХУЭМТөв болон ӨЭМТөвүүд дээр цусны даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор нийт 1600 үйлчилүүлэгчдын артерийн даралтыг хэмжиж эрт илрүүлэгээр 112 иргэнийг илрүүлж мэргэжилийн эмч нарын хяналтанд илгээсэн.





**3.**Төрийн албан хаагчидийн эрүүл мэндийн болон эрт илрүүлэлтийн үзлэгт 1300-д ажилчидыг хамруулав.Өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтанд хянагдаж байгаа 2,3 бүлгийн иргэдийг хүндрэлээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч 1560 иргэнийг шинээр хяналтанд авсан. Нийт 550 хүнийг эрүүлжүүлсэн. Эдгэрэл сайжирлын хувь 80.7 хувь байна. Өвчний эрт илрүүлэг зорилгоор нийт 15672 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн

2018 оны эхний 11 сарын ХБӨ-ний эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээний хамралтын байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

| Үзүүлэлт | 2017 оны **эхний 11 сараар/** | | 2018 оны **эхний 11 сараар/** | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| ХБӨ-үүд | Бодит тоо | хувь | Бодит тоо | хувь | Хувиар |
| Артерийн даралт ихдэх өвчин | 30763 | 79.3 | 32822 | 85.4 | 6.1 %-иар өссөн |
| ЧШӨ | 23966 | 61.8 | 27404 | 71.3 | 9.5%иар өссөн |
| Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг | 3194 | 32 | 2891 | 31 | 1% буурсан |
| Хөхний хавдрын эрт илрүүлэг | 17636 | 34 | 18352 | 41 | 7% өссөн |
| ХБӨ-ний илрүүлэгийн дундаж | 18889 | 51.70% | 20367 | 57.10% | 5.4-%иар өссөн |

Нийт ХБӨ-ний эрт илрүүлэгийн дундаж эхний 11 сарын байдлаар өнгөрсөн оны эхний 11 сараас 5,4%-иар өндөр байгаа нь эрт илрүүлэгийн үйл ажиллагаа хангалттай хэмжээнд явагдаж байгааг харуулж байна.

**4**.Дэлхий нийтээрээ **"Цусны даралт ихсэлттэй тэмцэх өдөр"-**ийг 2018 оны 05 сарын 17-ны өдөр Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Оном сангийн хамтарсан ЭРҮҮЛ ЗҮРХ ЭРҮҮЛ УЛААНБААТАР хөтөлбөрийн зүгээс **"130/80"** өдөрлөгийг **ЦУСНЫ ДАРАЛТАА ХЯНАЖ СУРЦГААЯ** уриан дор Сүхбаатарын талбайд зохион байгуулсан өдөрлөгийн үйл ажиллагаанд дүүргүүдийн эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хамтран оролцож иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох олон талт сургалт, зөвлөгөө, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог үнэ төлбөргүй үзүүлж иргэдэд үйлчилсэн. . Арга хэмжээний үеэр 400 орчим иргэний артерийн даралт үзэж мөн урьдчилан сэргийлэх сурталчилгааны материал 30-н төрлийн 1200 ширхгийг тарааж иргэдэд тараасан








**5**. Дэлхийн автомашингүй өдрийг 2018 оны 09 сарын 22-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсэн. Автомашингүй өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний үеэр Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв, Яармаг бүсийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа явуулж хамтран оролцож 25 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, 160 гаруй хүнд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сургалт сурталчилгаа хийж ажилласан. Мөн өдөрлөгийн үеэр иргэдийн дунд идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор хөгжөөнт тоглоом, дасгал хөдөлгөөн, спортын тэмцээн зохион байгуулсан.








**6. Чихрийн шижин өвчинтэй тэмцэх өдрийн хүрээнд**:" Гэр бүл ба чихрийн шижин" уриан дор ХУДНДГ нийт 56 ажилчдаас 54 нь хамрагдаж биеийн өндөр, жин, АД, пульс, SpO2, захын цусанд сахар, холестерин тодорхойлж хүн тус бүрт зөвлөгөө өгсөн. Глюкозын өөрчлөлттэй 1 хүн гарсаныг нарийн шинжилгээнд явуулав.ЧШӨ шинээр оношлогдсон 1 хүн, ЧШӨ оношлогдсон 1 хүн байсан.Хан-Уул эрүүл мэндийн төвийн амбулаториор үйлчлүүлэгчдийн дунд Чихрийн шижин өвчний талаар орчин үеийн мэдээлэл өгч, өөрийн хяналтыг сайжруулах, чихрийн шижин хэв шинж-2 үеийн хоол эмчилгээ, дасгал хөдөлгөөний тухай 120 гаруй иргэдэд сургалт явуулав. Сургалтын үеэр 42 иргэний цусан дахь глюкозын хэмжээг тодорхойлсон. Мөн иргэдэд өглөөний цай бэлтгэн өгсөн /цагаан лууван, огурцыны салат болон бууцайны шүүс/. ЧШХШ-2 той 100 гаруй иргэдэд гарын авлага тараалаа. "

   

Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдрөөр Чихрийн шижин айл бүрийн хаалгыг тогшиж байна уриан дор тэмдэглэн өнгөрүүлж ХУДНДХэлтэсийн 54 ажилтан албан хаагчдад эрүүл мэндийн үзлэг хийж зөвлөгөө өгөв.

  

**7**. Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал, зуршил сэдвээр Мега эмийн компанитай хамтран ХУЭМТ-ийн нийт ажилчидад ,“Зөв зохистой хооллолт”, ”Дасгал хөдөлгөөн” сэдэвээр ИНЕГ-ын Холбоо Навигаци Бодит Ажиглалтын үйлчилгээний алба, Дулаан Түгээх Баруун Бүс Сүлжээ Компаний нийт ажилчидад 3, 16, 7, 8, 12, 13 хорооны ахмадуудад, УБЦТС ХХК, ХУД нутаг дэвсгэр дээр байрлах их дээд, ТМСургуулиуд,ХУЭМТөвөөр үйлчилүүлэгчид, хэвтэн эмчилүүлэх тасаг, зэрэг нийт 14 байгуулагын 9322 хүнд хийв. зохион байгуулсан Дэлхийн чихрийн шижинтэй тэмцэх өдрийн хүрээнд төлөвлөгөө гарган ажилласан.
2018,11,13 нд

   

ТВ-5,LIKE телевизээр ХБӨ,зохистой хооллолт,элэгний вирусийн илрүүлэг,эмчилгээ,хяналт,осол гэмтэлийн тухай мэпээлэл,зөвлөмж,ярилцлага хийв





**8.**Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах сарын аяны хүрээндЭМТ-ийн нийт 192 эмэгтэй эмч, сувилагч , дунд мэргэжилтэн, үйлчлэгч нарыг Эмэгтэйчүүдийн кабинет, Хавдар судлалын кабинет , Хавдар бүртгэгч нар хамтран Умайн хүзүүний эсийн шинжилгээ, Хөхний эрт илрүүлэг үзлэгт хамрууллаа

Хорт хавдрын шинэ өвчлөл CANREGMON программд -205 өвчлөл, H-Info программ-189 шинэ өвчлөл шивж мэдээлсэн

**<u>Хүн амын насжилтыг дэмжих, ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ</u>**:

Өрхийн эмч нар ахмадын эмчтэй хамтран 55-с дээш насны эмэгтэй, 60-с дээш насны эрэгтэй ахмад настны бүртгэл судалгааг улирал бүр шинэчлэн гаргаж ахмадын бүртгэл судалгааны мэдээллийн сантай болсон Үүнд: Ахмад настан 10662, үүнээс эмэгтэй-8262, ахмад дайчин 34, 100-с дээш настан-2, нэн ядуу-136, ганц бие- 151, байнгын асаргаанд 1592 настан байдаг. Эрүүл мэндийн бүлгээр авч үзвэл:

- 1-р бүлэгт -0
- 2-р бүлэгт- 1258
- 3-р бүлэгт- 5616
- 4-р бүлэгт -3730
- 5-р бүлэгт -58 ахмад байна.

ХУД-ийн 1–16-р бүх хороодын ахмад настнуудад халдварт болон халдварын бус өвчний эрт илрүүлэг хийх урьдчилан сэргийлэх үзлэгийг /дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хавдар, нүд лор,сүрьеэ, арьс харшил, ЭХО, зэрэг/ төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй баг нийт 8243 ахмадуудад хийсэн. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2807 ахмадуудыг элэгний В,С вирус илрүүлэх эрт илрүүлгийн шинжилгээнд хамруулсан

  

Эрүүл мэндийн 4 ба 5-р бүлэгт хамрагддаг 3788 ахмад настанд гэрийн эргэлтийг графикийн дагуу хийж шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмч нарт дуудлагаар үзүүлж байна. Давхардсан тоогоор 45456 настанд гэрийн эргэлт үзлэг, эмчилгээ, оношлогоо хийж , өдрийн эмчилгээнд -385, тасагт хэвтүүлэхээр -348, яаралтай тусламж үзүүлэхээр -196 ахмадыг тус тус илгээж эмчилгээ тусламж үйлчилгээнд хамруулсан байна. Эрүүл мэндийн 4-р бүлгийн нийт 168 ахмадуудыг шинээр байнгын асаргаанд тодорхойлж нийгмийн асуудлыг сайжруулсан.Мөн сэргээн засах эмчилгээнд-1250,сувилалд-258,хөнгөлөлттэй эм олголтонд-2022 ахмадыг хамруулсан

Эрүүл мэндийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай туслах хэрэгслүүд шаардлагатай байгаа ахмад настнуудын судалгааг тодорхойлолтуудыг гарган дүүргийн халамжийн хэлтэст хүргүүлэн халамжаас ортез, протез, туслах хэрэгслийг нийт 728 ахмадуудад үнэ төлбөргүй олгуулсан .Үүнд: Нүдний шил хийлгэсэн-95, сонсголын аппарат олгосон-141, Хиймэл шүд хийлгэсэн-446, нүдний болор суулгасан35, тэргэнцэр -476, таяг- 802 хүнд тус тус олгосон

Ахмадын Эрүүл мэндийг дэмжих зорилгоор “Ахмадын эрүүл мэндийг дэмжих” сарын аяны хүрээнд 16 хорооны 54 ахмадуудын дунд эрүүл зөв зохистой хооллолтын талаар болон идэвхтэй хөдөлгөөний талаар 7 хоногийн сургалт зохион байгууллаа.

   

“Ахмадын эрүүл мэндийг дэмжих” сарын аяны хүрээнд ХУД-ын ахмадын хороотой хамтран 2018.10.27 нд ахмадуудад зориулсан сургалт өдөрлөг зохион байгууллаа. Тус өдөрлөгт 66 ахмад настан хамрагдаж, “Эрүүл урт наслахуй” лекц, “Хийн дасгал”-ийн сургалтанд хамрагдаж “Анун гоо” эмийн компанийн сургалт, цай кофегоор дайлуулж, 5 төрлийн 150 ш гарын авлага брошур тараагдлаа.

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>




<br>
Ахмад настны дунд эрүүл аж төрөх зан үйлийг дэмжих тасралтгүй сургалт сурталчилгааг графикийн дагуу дараах сэдвүүдээр явуулсан. Үүнд: Осол гэмтлээс сэргийлэх, Эрүүл зөв хооллолт, Дасгал хөдөлгөөний ач холбогдол, Архи тамхины хор уршиг, эмийн зохистой , Хорт хавдараас сэргийлье, АД ихсэх өвчнөөс сэргийлье, Чихрийн шижин чимээгүй тахал, идэвхитэй хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих иог дасгал сэдэвт сургалтуудад нийт 6923 ахмад хамрагдсан. \ 64,9%\
<br>



<br>
“Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд:
</td>
</tr>
</table>

НЭМГ –аас “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн 2 дахь шатны нээлтийн үйл ажиллагааг Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулахад ХУЭМТөв, ӨЭМТөвийн 25 эмч, оролцож 1475 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж илрүүлэг үзлэг шинжилгээ хийсэн.





Дүүргийн хэмжээнд 15-39 насны хамрагдвал зохих 74044 хүнээс 9432 хүн хамрагдсан.Хамралтын хувь-12,7%

40-65 насны хамрагдвал зохих 37779 хүнээс 22667 хамрагдсан. Хамралтын хувь-60% байна.Үзлэг шинжилгээгээр

В вирустэй илэрсэн 1486 хүнээс 172 нь буюу 11,5% нь, С вирустэй илэрсэн 3662 хүнээс 488 хүн нь буюу 13,3% нь тус тус эмчилгээнд хамрагдсан байна. Илрүүлэг шинжилгээнд хамрагдаад В вирус сөрөг гарсан 26951 иргэнээс 18983 нь буюу 70,4% нь В вируст гепатитийн эсрэг сайн дурын дархлаажуулалтанд хамрагдсан байна.
Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн насны хүмүүсээс гадна дүүргийн 107 аж ахуйн нэгж байгууллагын 6153 иргэнийг илрүүлэг шинжилгээнд хамруулсан.
Дүүргийн хэмжээнд хепатитийн вирусын архаг халдвартай, элэгний хатууралтай иргэдийн элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10,2% -иар өссөн үзүүлэлттэй байна
Хан-Уул дүүргийн “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн тоон тайлан

| № | Нас | | Тоо | Хувь |
|---|---|---|---|---|
| Эрт илрүүлэг | 15-39нас: | Хамрагдвал зохих тоо | **74044** | **12,7%** |
| | | Хамрагдсан тоо | **9432** | |
| | Үүнээс | В вирустэй илэрсэн хүний тоо | **426** | **4,5%** |
| | | С вирустэй илэрсэн хүний тоо | **285** | **3%** |
| | 40-65 нас: | Хамрагдвал зохих тоо | **37779** | **60%** |
| | | Хамрагдсан тоо | **22667** | |
| | Үүнээс | В вирустэй илэрсэн хүний тоо | **1060** | **4.7%** |
| | | С вирустэй илэрсэн хүний тоо | **3377** | **14.8%** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Албан байгууллага | Илрүүлэг хийсэн аж ахуй нэгжийн тоо | **107** | **6339/6153-97,1%** |
| Эмчилгээ | ВГС-ийн эмчилгээ | Хамрагдсан хүний тоо | **488** | **13,3%** |
| | | Үүнээс эдгэрсэн хүний тоо | **317** | **65%** |
| | ВГВ-ийн эмчилгээ | Хамрагдсан хүний тоо | **172** | **11,5%** |
| | | Үүнээс эдгэрсэн хүний тоо | **5** | **2,9%** |
| | В вирусын эсрэг вакцинд сайн дураар хамрагдсан иргэдийн тоо | | **18983** | **70,4%** |

**Эмчилгээнд хамрагдсан байдал:**2018 оны эхний 10 сарын байдлаар ВГС-ийн эмчилгээнд 488 хүн хамрагдсанаас 317 хүн /65%/ нь, ВГВ-ийн эмчилгээнд 172 хүн хамрагдаж 2,9% нь тус тус эдгэрсэн байна






ЭМТ-ийн хэмжээнд ажиллаж байгаа нийт 224 эмч эмнэлгийн ажилтнуудын дунд гепатитын В,С вирусын тандалт судалгааг хийхэд В вирустэй 20 /буюу 9,8%/, С вирустэй 30 буюу 13,3% нь тус тус хепатитын вирусийн халдвартай байна. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар"-ын хүрээнд Поликлиникийн тасгаас санаачлан Элэгний В,С вирусын идэвхжил тоолох шинжилгээг Гэгээн Ар Үр эмнэлэгтэй хамтран үнэ төлбөргүй хамрууллаа. Эдгээр эмч ажилчдаас 20 хүнийг вирусийн идэвхижил үзүүлэх шинжилгээнд хамруулж 4 хүнийг эмчилгээнд хамруулсан





**Сургалт сурталчилгаа**:

Хепатиттай тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Хепатитыг илрүүлье, эмчилье” уриан дор 2018 оны 07-р сарын 25-27-ны өдрүүдэд дараах ажлуудыг зохион байгуулан хийж гүйцэтгэлээ.Үүнд:

ЭМТ-ийн амбулаториор үйлчлүүлэгчдийн дунд 2018 оны 07-р сарын 25-ны өдөр “Элэгний В,С вирус гэж юу вэ?”, “Элэгний В,С вирусын эмчилгээ” гэсэн 2 төрлийн сэдвээр Хоол боловсруулах кабинетын эмч нар сургалт хийж төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, сувилахуйн алба хамтран 10 гаруй төрлийн 300 орчим гарын авлага материалыг тарааж зөвөлгөөг өглөө.Сургалтанд 50 гаруй хүн хамрагдлаа.

Байгууллагын вэб сайт






болон цахим хуудас, тасаг нэгжүүдийн мэдээллийн самбаруудад 4 төрлийн сурталчилгааны материалыг тавьж иргэдэд сурталчилгаа хийлээ.








.Сүхбаатарын талбай дээр зохион байгуулсан Хепатиттай тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэх нэгдсэн үйл ажиллагаанд 8 эмч мэргэжилтнүүд оролцож 178 хүнд илрүүлэг шинжилгээ хийж сурталчилгаа хийж гарын авлага материал тарааж 78 хүнд зөвөлгөө өгсөн. ӨЭМТ –үүд хепатиттай тэмцэх дэлхийн өдрийг хүрээнд үйлчлүүлэгчдийн дунд сургалт сурталчилгаа хийж В,С вирусын илрүүлэг шинжилгээнд нийт 103 хүнийг хамруулсан байна






**<u>Сэтгэц, наркологийн чиглэлээр</u>** :

2018 оны 10 сарын байдлаар Сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаар үйлчлүүлсэн нийт иргэдийн тоо:
Бүгд үзлэг-13013
Урьдчилан сэргийлэх үзлэг-6627
Идэвхитэй хяналт-1103
Сэтгэл зүйн зөвлөгөө болон сэтгэл заслын эмчилгээг нийт- 305 иргэнд давхардсан тоогоор 385 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал хийгдсэн байна

**Ухаарал"** аяны хүрээнд ХУД-ийн цагдаагийн 1-р хэсэгт байрлах түр саатуулах байранд хоносон 16 иргэнд **"Согтууруулах ундааны хор уршиг"** сэдэвт эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл хийж гарын авлага тараах материалыг тараасан. Хан- Уул дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба ХУЭМТ-н сэтгэцийн эрүүл мэнд , наркологийн кабинет хамтран ЕБ-н 10, 26, 59,75, БУ- Цогцолбор сургуулиуд дээр "Архи тамхи, сэтгэц нөлөөт бодисын хорт нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам" сэдэвт сургалтыг хийж нийт 760 хүүхэд хамрагдлаа Мөн ЕБС-ын 7,32,115,15,75, 41 болон Оном сургуулийн нийт – 1646 сурагчдад "Өсвөр насны сэтгэцийн эрүүл мэнд ба мансууруулах бодисын хор нөлөө "сэдвээр , Монгол Солонгосын хамтарсан политехникийн коллежийн оюутан сурагчдад "Архи, согтууруулах ундааны хор уршиг", "Өсвөр насны сэтгэцийн эрүүл мэнд", "Дэлгэцийн донтолт" гэсэн сэдвүүдээр сургалт зохион байгуулан нийт 12 удаагийн сургалтанд 1823 хүнийг тус тус хамруулсан байна







.Мөн БЗДХӨ/ХДХВ/ДОХ-ын кабинет, Өсвөр үеийн кабинеттай хамтран Тамхины эсрэг өдөр: Хан – уул" эрүүл мэндийн төвийн сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинет 4, 5, 6, 7, 8-р хорооны ӨЭМТ-үүд, "Омбол" эмийн компанитай хамтран дэлхийн тамхигүй өдрийг "Тамхи зүрхэнд хортой, тамхиа хаяж эрүүл мэндээ сонгоцгооё" уриан доор "Хүннү Молл" их дэлгүүрт эрүүл мэндийн өдөрлөгийг зохион байгуулж 260 гаруй иргэд олон нийтэд тамхины хор хөнөөлийн талаарх сургалт мэдээлэлийг өгч, гарын авлага санамж зөвлөмжийг тарааж тамхинаас татгалзах иргэдийн гарын үсгийг цуглуулж тамхинаас татгалзахыг уриаллаа. Өдөрлөгт оролцсон иргэдийн дунд "Тамхины хор хөнөөлийг хэн сайн нэрлэх вэ?" хөгжөөнт тэмцээн, бяцхан оролцогчдын дунд "Манай гэр бүл тамхигүй гэр бүл" сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж ялагчийг тодруулан, мөн уралдаанд оролцогчдыг шагнаж урамшууллаа.

| | | |
|---|---|---|
| | |    <br>Сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаас 2018 оны 6 сард ӨЭМТ-н эмч, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах “Архи тамхи, мансууруулах, сэтгэц идэвхит бодисын хэрэглээ, түүний эрсдлийг эрүүл мэндийн анхан шатны байгууллагын түвшинд эрт илрүүлэн, үнэлж, богино хугацааны эрчимтэй зөвлөгөө өгөх /Assist/ сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд НЭМГ харъяа Наркологийн эмнэлэг, “Сандоз”, “Олайнфарм” эмийн кампаниуд хамтран сургалтыг дэмжин оролцлоо. Сургалтанд нийт 32 өрхийн эмч хамрагдлаа. Мөн Гаалын ерөнхий газартай хамртан “Хар тамхи, Мансууруулах бодисоос урьдчилан сэргийлье” сэдвээр сургалт хариуцсан мэргэжилтэн Ганболд мэдээлэл хийлээ. Тус сургалтанд монгол улсад мансууруулах бодисын өнөөгийн байдал болон хил гаалийн илрүүлэлт, манай оронд хэрэглэгдэж буй болон шинээр гарч ирж буй мансууруулах төрлийн бодисын талаар мэдээлэл хийсэн ба 36 эмч, ажилчид хамрагдла<br>    |

Оюутны эрүүл мэндийг дэмжих сар”-н аяны хүрээнд сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинет “Архи-тамхины хор хөнөөл, мансуурлын эсрэг хамтдаа” сэдэвт сургалтыг Орхон ДС, МИС-д Монгол Солонгосын хамтарсан коллежийн нийт-350 оюутанд сургалт хийлээ. Хан- Уул дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба ХУЭМТ-н сэтгэцийн эрүүл мэнд , наркологийн кабинет хамтран Технологийн дээд, Орхон, Аврага, ҮЭЗД, Монгол Солонгосын хамтарсан Политехникийн коллеж, Тэнгэр, ХААИ сургуулиуд дээр “Архи тамхи, сэтгэц нөлөөт бодисын хорт нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтыг нийт -1286 оюутан залууст хийсэн





ХУД-н сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаас “Архи, тамхины хор хөнөөл””Стресс менежмент” сэдэвт сургалтыг 2018 оны 8-р сард дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн ажилчдад ,“Архинд донтох өвчин гэж юу вэ?” сэдвээр хороодын нийгмийн ажилчид болон хэсгийн ахлагчдад тус тус сургалт хийж нийт 52 хүн хамрагдлаа..






.

**<u>Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийх явуулын үйлчилгээг идэвхжүүлэх зорилтын хүрээнд :</u>**

Урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн байдал

*- 2017 он* *- 2018 он*

| Эмнэлэг | Хийгдсэн газар | | Хамрагдсан хүний тоо | | Өвчтэй илэрсэн | | Тархалт | | Эрчим | | Үзлэгэ эрүүлж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ХУЭМТ Амбулатори №1 Шүдний кабинетууд | 41,53,28,46,134,49 цэцэрлэг 75, 60,118-р сургууль | 29,46,71,73,230 35,218 цэцэрлэг 7,52,15,75,32, 130,118,34,41, 60 сургууль | 4166 | 7303 | 2895 | 5710 | 69,5% | **78,2%** | 4 | **5** | 347 (12%) |
| | Цэргийн насны залуучууд 34-р сургууль,ХААИС | | 2019 | 2172 | 666 | 695 | 33% | **32%** | 3 | **3,2** | 40 (6%) |
| | Кабинет | | 3252 | 3003 | 1577 | 1411 | 48,5% | **47%** | 4 | **4** | 252 (16%) |
| Нийт | 12 байгууллага | 19 байгууллага | 9437 | 12478 | 5138 | 7816 | 54,4% | **62%** | 3 | **4** | 580 (11,3%) |

- Зориудын урьдчилан сэргийлэх үзлэгээр 7 цэцэрлэг, 10 сургуулийн нийт 7303 хүүхэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Энэ нь урд онтой харьцуулбал 3137 хүүхдээр их байна.

Шүд цоорох өвчний нийт тархалт 0-10 насанд 78,2%, эрчим 5 байв. 5-6 насанд шүд цоорлын тархалт 86,4%, эрчим 6, 12 насанд тархалт 63%, эрчим 2,3 байлаа. Энэ нь урд онтой харьцуулбал 0-18 насанд тархалт 0,5 % - р, 5-6 насанд тархалт 3,4%,12 насанд тархалт 4%-р ихэссэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт ихэсч, ялангуяа дүүргийн захын хороодын сургууль,цэцэрлэгийн хүүхдүүд ихээр хамрагдсантай холбоотой шүд цоорох өвчний тархалт, эрчмийн үзүүлэлт урд онтой харьцуулахад тархалт 7,6%-р,эрчим 1 промилээр ихэссэн үзүүлэлттэй байна.

- . Урьдчилан сэргийлэхээс эрүүлжсэн нийт эрүүлжилт 12%-тай байна.







    

- ХУД- ийн харъяа цэргийн насны залуучуудын амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 2172 хүн хамрагдсанаас 695 буюу 32% нь амны хөндийн өвчлөлтэй илэрсэн байна. Энэ үзүүлэлт нь урд онтой харьцуулбал ойролцоо түвшинд байна. 2017 онд үзлэгт хамрагдан өвчтэй илэрсэн залуучуудаас 40 хүн буюу 6% нь бүрэн эрүүлжиж, энэ оны эрүүлжүүлэлт одоогоор 13 хүн буюу 1,9% -ийн явцтай байна.
- 2018 онд нийт 19 байгууллага дээр 12478 хүнийг амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, нийт өвчний тархалт 62%тай, эрчим 4 байна. Урьдчилан сэргийлэхээс эрүүлжсэн нийт эрүүлжилт 12%-тай байна.
- 2018 оны байдлаар нийт 29466 хүнд амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийж, өвчний улмаас нийт 16988 хүн үзүүлснээс анхдагчаар 13527 хүнд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үзүүлж, 6222 буюу 46%-г эрүүлжүүлэн ажиллаа. Нийт үзлэгийн 4351 буюу 25,6%-г хүүхдийн үзлэг эзэлж байна Анхдагчаар 2959 хүүхэд үйлчлүүлснээс 1449 буюу 49% нь эрүүлжүүлсэн байна.Энэ нь урд онтой харьцуулбал 3%-р өссөн байна.
- ХУЭМТөвийн шүдний кабинетээс “Эрүүл хүүхэд - Эрүүл шүд” жилийн аяныг зохион байгуулж, зориудын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс хамгийн их шүд цоорлын өвчлөлтэй гарсан 75-р сургуулийн 4б ангийн хүүхдүүдийг 100% эмчлэн эрүүлжүүлж, ”Эрүүл шүдтэй анги” өргөмжлөл гардууллаа.
- Халамжийн 28-р цэцэрлэгийн бэлтгэл ангийн хүүхдүүдийг 100% эрүүлжүүлж төгсгөлөө.
- Халамжийн 4-р яслийн хүүхдүүдийн эрүүлжүүлэлт 85% явагдлаа.

    

ХУД-ийн харъяа 6 цэцэрлэг, 10 сургуулийн 4311 хүүхэд, кабинетаар 837 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн талаар видео хичээл, лекц, ганцаарчилсан болон харилцан яриа, АХА тэмцээний хэлбэрээр сургалтыг явуулж, нийт 5148 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олголоо. ХУД-ийн 32, халамжийн 28-р цэцэрлэгийн 16 багш, 8 хүүхдэд тусгайлан сургалт явуулж, хүүхдүүдэд сургалт хийлгүүлэн шалгах замаар амны хөндийн эрүүл мэндийн сургагч багш, хүүхдүүдийг бэлтгэлээ..Халамжийн 4-р яслийн бага бүлгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд хүүхдийн шүдийг багаас нь хэрхэн арчлах талаар сургалт явууллаа. Нийт 32 эцэг эх хамрагдлаа.

| | | |
|---|---|---|
| | | Дэлхийн амны хөндийн эрүүл мэндийн өдөр”-т зориулж шүдний кабинетүүдээс өдөрлөг зохион байгуулж, өдөрлөгийн үйл ажиллагаанд оролцсон иргэдэд шинээр боловсруулсан амны хөндийн эрүүл мэндийн сэдэвт сурталчилгааны санамж, материалыг тарааж, шүдэнд ээлтэй хоол хүнсний талаар зөвлөгөө өгч, ”Сүү” ХХК-ны кальци, Д витаминаар баяжуулсан сүүгээр үйлчиллээ.ХУД-ийн харъяа цэцэрлэг, сургуулиудын эмч нар, эцэг эхийн төлөөлөлд “Амны хөндийн эрүүл мэндийн сургалтыг хэрхэн явуулах вэ?” сэдэвт сургалт явууллаа. Нийт 24 хүн оролцлоо . Амны хөндийн эрүүл мэндийн сэдэвт 2 төрлийн санамжийг шинээр боловсруулан гаргаж, 450 ш-г сургууль, цэцэрлэгээр тараасан байна.<br>     |
| | | **Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулах зорилгоор ӨЭМТ -үүдтэй хамтарч халдварт өвчний тандалт, судалгааг хийж, өвчлөлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулна. Өртөмтгий бүлгийн иргэдийг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах зорилтын хүрээнд :**<br><br>НЭМГ-ын А/34, ХУДЭМТ-ийн А/28, ХӨСҮТ-ын 9/162 Сүрьеэгийн тусламж үйлчилгээг эрчимжүүлэх зааврыг мөрдлөг болгон “Сүрьеэгүй дүүрэг” болгох зорилго тавин 2018-2019 Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааны 16 зүйл бүхий төлөвлөгөө, “Сүрьеэгүй Хан уул” 3 сарын төлөвлөгөө гарган 4 зүйл бүхий 20 ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>ХУД ЗДТГНХХ ,ZERO-TB, MHI Харвордын ЭШСТ хамтран “Сүрьеэгүй Хан –уул” үйл ажиллагааг 2018-2019 онд хэрхэн зохион байгуулж явуулах талаар 2,3-р сард 2 удаа зөвлөлдөх уулзалтын зохион явуулж төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>   |

“ МӨАУМХ ХУД-ийн ЗДТГ НХХэлтэс ,ЭМТ Сүрьеэ диспансер , 16 хороодын засаг дарга , Өрхийн ахлагч нарыг хамруулан Сүрьеэгүй дүүрэг хороо өрх болоход анхаарах зүйлс, өвчлөлийг эрт илрүүлэхэд хороо өрхийн хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах, эрсдэлт бүлгийн иргэд, эмчилгээ хийгдэж байгаа, хяналт алдагдсан хүмүүстэй хэрхэн хамтарч ажиллах талаар Сүрьеэгүй дүүрэг” болох ухуулга нөлөөллийн уулзалтыг зохион байгуулсан






Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн арга хэмжээг НЭМГ-ын даргын А/34 дүгээр тушаал, ЭМТ-ийн даргын А/28 тушаалын дагуу удирдамж төлөвлөгөө гарган 3-р сарын 14-өөс 4-р сарын 07-ны хооронд “Сүрьеэг устгая” уриан дор олон нийтэд чиглэсэн томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж байгаагийн нэг нь “Сүрьеэгүй Хан-уул” өдөрлөг юм.







Уг өдөрлөгийн хүрээнд сүрьеэ өвчинтэй тэмцэх үйл хэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулах, хүн бүрийн хүчин чармайлт чухал гэдгийг сурталчлан таниулах зорилгоор халдварын тархалт, халдвараас сэргийлэх талаарх мэдээллийг хийж, иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх замаар эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

**Сургалт сурталчилгаа:** Сургалтын төрөл, хамрагдсан хүний тоо

| № | Төрөл | тоо |
|---|---|---|
| 1 | Сургалт сурталчилгаанд хамрагдсан хүүхдийн байгууллагын багш ажилчид, сурагчдын тоо | 1975 |
| 2 | Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо | 2358 |
| 3 | Өдөрлөг, АХА, зургийн тэмцээн зэрэг арга хэмжээнд оролцсон иргэдийн тоо | 1516 |
| 4 | Сургалтанд хамрагдсан ӨЭМТ-ийн хүүхдийн байгууллагын эмчийн тоо | 50 |

| | | |
|---|---|---|
| 5 | Сургалт, ярилцлаганд хамрагдсан өвчтөний тоо | 125 |
| 6 | Явган аялал | 40 |
| 7 | Нийт хамрагдсан хүний тоо | 6054 |

Дүүргийн онцгой байдлын хэлтэс, Улаан загалмайн хороо ЭМТөвийн Сүрьеэ диспансер, БЗДХ-ын кабинет хамтран 3-р сарын 26-нд **Хүннү-Молл цогцолборт** ард иргэдэд ”Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Бид нэг агаартай сүрьеэ өвчнөөр хэнч өвдөж болно”, ”Гар халдваргүйтгэх арга, гараа хэрхэн зөв угаах “ Сүрьеэг тэглэе “ сэдвээр сургалт хийж, дүүргийн 4,5,6,9,16-р хороодын иргэд идэвхтэй оролцож сурталчилгаа явуулан 250 хүн хамрагдаж сурталчилгааны материал тарааж, NTB телевиз-д иргэдэд зориулсан ярилцлага өгөн ажиллалаа.





Сүрьеэ диспансераас болон ӨЭМТ-үүд Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 41 удаагийн сургалт хийж 2358 иргэд хамрагджээ. Нийт 2425 сурталчилгааны материал гарын авлага тараасан. 416000 төгрөг зарцуулсан.






ӨЭМТ-үүдийн сүрьеэ хариуцсан эмч нар, 2017, 2018 онд сүрьеэ өвчний тохиолдол бүртгэгдсэн ерөнхий боловсролын сургуулийн эмч нар нийт 30 эмч мэргэжилтнүүдэд ХӨСҮТ-ийн сүрьеэ тандалтын албатай хамтран “Сүрьеэгийн эмийн менежмент”, “Сүрьеэгийн халдвар хяналт” сэдвээр дүүргийн харьяа сургууль, цэцэрлэгийн нийт 20 эмч мэргэжилтнүүдэд сургалт хийж ажилласан.







ХУД -ийн 16 өрхийн ахлагч, сүрьеэгийн хөтөлбөр хариуцсан эмч сувилагч 35 мэргэжилтэнд Сүрьеэгийн эрт илрүүлгийг чанаржуулах ДОТС-ыг өрхийн эрүүл мэндийн төвд чанартай хийх , хавьтлын хамралтыг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах талаар сургалт хийж зөвөлгөө өгч ажиллаа.





ХУД-ийн 1,2,3,11,15 хороодын ӨЭМТ-үүдэд дэмжлэгт хяналтыг “Дэмжлэгт хяналт зохион байгуулах тухай” ЭМТ-ийн даргын А/25 тушаалын дагуу ХӨСҮТын СТСА ны дүүрэг хариуцсан мэргэжилтэн Доржмаа, Чинзориг нарын хамт удирдамжийн дагуу “Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд өрхийн эрүүл мэндийн төвийн оролцоо” сэдвээр заавар зөвлөмж өгч, эрт илрүүлэлтийн хамралтыг сайжруулан, ДОТС-эмчилгээг хяналтай хийж хэвших , хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамралтыг 98% дээш тогтмол хамруулж хэвших ,сорьц тээвэрлэлтийг сайжруулан чанартай тусламж үйлчилгээг хийж хэвших талаар үнэлгээ хийж газар дээр нь гарсан дутагдлыг сайжруулах зөвлөмж өгч ажиллалаа. Мөн 16 ӨЭМТ-д МӨЭМХ-той хамтран дэмжлэгт хяналт хийж, үнэлгээ өгсөн.







**Идэвхтэй эрт илрүүлэг:**

Бүх хэлбэрийн сүрьеэгийн илрүүлэг дүүргийн хэмжээнд 2017 онд 37,8% байсан ба 2018 оны эхний 10 сарын байдлаар 39,2%-д хүргэн ажиллаа.

ЭМС-ын 2017 оны 306 тушаалын дагуу эрсдэлт бүлгийн судалгааг 5 чиглэл, 22 бүлгээр 11294 хүний судалгааг шинэчлэн гаргаснаас 2018 оны эхний 10 сарын байдлаар 8790 иргэн буюу 77,8% нь үзлэгт хамрагдаад байна.

- 2018 оны 4-5-р сард ЭМТ, ӨЭМТ, сургуулийн захиргаатай хамтран хүүхдийн байгууллагад бүртгэгдсэн сүрьеэгийн ойрын хавьтлуудад эрт илрүүлэг зохион байгуулж ХӨСҮТ-ийн сүрьеэ тандалтын алба, хорих ангиас зөөврийн рентген аппарат, рентген техникчтэй хамтран ажилласан Үүнд: 2018 онд сүрьеэ бүртгэгдсэн 7 ерөнхий боловсролын сургууль хамрагдсан.
- Туберкулины сорил- 487 сурагч,
- Сүрьеэ илрүүлэх асуумж судалгаа- 1977 багш ажилчид, сурагч,
- Цэрний түргэцийн болон жене Xpert шинжилгээнд – 113 багш ажилчид, сурагч,
- Рентген шинжилгээнд - 1977 багш ажилчид, сурагч хамрагдсан.
- Үүний дунд: 15 сурагч, багш сүрьеэгийн эмчилгээнд орсон.





5 их дээд сургуулийн 672 оюутан залууст, 3 удаа 633 эрсдэлт бүлгийн иргэдэд НЭМГ-ын зөөврийн рентген аппаратаар эрт илрүүлэг зохион байгууллаа. Үзлэгийн үеэр дүүргийн Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран оюутан залуусыг сайн дурын эрүүл мэндийн даатгалд хамруулж ажилласан






- Мөн 4,5,6,7,8,9,10, хороодын эрсдэлт бүлгийн120 хүнийг рентген шинжилгээнд хамруулан 4 идэвхтэй хэлбэрийн уушигны сүрьеэ илрүүлэн эмчилгээнд хамруулсан.
- Цэргийн албанаас чөлөөлөгдсөн дүүргийн харьяа 5 иргэнийг үзлэгт хамруулж 2 идэвхтэй хэлбэрийн сүрьеэг илрүүлж эмчилж байна.

Алслагдсан хороод Өлзийт Туул тосгон Био комбигатад сайн дурын идэвхтэн 4 хүнийг сурган нийт 8 хүний эмчилгээг гэрээр хүргэн уулгаж байна. Эрсдэлт бүлгийн хүн амд эрт илрүүлгийг гэрээр очиж хийх сайн дурын 14 хүнийг сурган “Дэмжих бүлэг “ ажиллаж 3 хүнийг илрүүлэн эмчилгээнд хамрууллаа.
Эмзэг бүлгийн 15 өвчтөнд эмчилгээний хугацаанд сар бүр 30,000-10 50.000-5 төгрөгийн хүнсний тусламжийг МСТН Глобаль сантай хамтран олгож байн.ЗДТГын НХХэлтэстэй хамтран одоо эмчилэгдэж байгаа 140 хүмүүсийн амжиргааны түвшин тогтоож хороодын засаг дарга нартай хамтран хүнсний болон бусад тусламжинд хамруулах арга хэмжээ авснаар эмчилгээ таслалт 7% иас 2% болж буурсан
.





Архидан согтуурахтай тэмцэх "Ухаарал" аяны хүрээнд Сэтгэцийн эрүүл мэнд, Наркологийн кабинет, Цагдаагийн 1,2-р хэлтэстэй хамтран Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх албадан эмчилгээнд хамрагдах иргэдийг Нарийн мэргэжлийн эмч нар нэг цэгийн үйлчилгээг гарган үзлэгт хамруулж, албадан эмчилгээнд илгээлээ. Нийт 25 хүнийг . Цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран орон гэргүй **14**, албадан эмчилгээний **11**, хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажилд зуучлуулж байгаа **17** залуучуудад илрүүлэг шинжилгээнд хамруулсан. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа

зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг бүртгэлжүүлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс албадын хамтран зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 100 гаруй иргэдийг эрүүл мэндийн үзлэг /цээжний рентген зураг, дотор, арьс харшил, ДОХ/БЗХД өвчний үзлэг, сэтгэл зүйн зөвлөгөө, цусан дахь сахарын хэмжээ үзэх, ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээ/-нд тус тус хамруулллаа.






**Илрүүлэг 2018 оны 10 сараар**

| № | **Идэвхтэй ируулгийн төрөл** | Хамрагдсан хүний тоо | | Илэрсэн хүний тоо | Эмчилгээнд хамруулсан хүний тоо |
|---|---|---|---|---|---|
| 1. | Ерөнхий боловсролын сургууль | 1977 | 7 ЕБС | 15 | 15 |
| 2. | Эрсдэлт бүлгийн хүн амын дунд | 633 | 3 удаа | 4 | 4 |
| 3. | Өрхийн хавьтал | 580-аас 484 | 222 өвчтөний | 33 | У/с-х эмчилгээнд 27, идэвхтэй хэлбэр 6 |
| 4. | Оюутан залууст | 672 | 5 их дээд сургууль | 1 | 1 |
| 5. | Цэргийн насны залуус | 4702 | 2 удаа | 2 | 2 |
| 6. | Албан байгууллагууд | 2147 | 112 байгууллага | 2 | 2 |
| 7. | Нийт | 10615 | | 57 | 57 |

**Хавьтлын хамралт**

| № | Он | Хамрагдвал зохих хавьтлын тоо | Хамрагдсан хавьтлын тоо | Хамратлтын хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 2015 он | 534 | 267 | 50% |
| 2 | 2016 он | 331 | 226 | 68% |
| 3 | 2017 он | 300 | 182 | 60% |
| 4 | 2018.10 | 398 | 320 | 80,4% |

**Үзлэг шинжилгээ**

| Илрүүлэг шинжилгээ үзлэг | 2017 он | 2018 оны 10 сар |
|---|---|---|
| Бүгд үзлэг | 5339 | 6600 |

| | | |
|---|---|---|
| Шинэ сүрьеэ | 230 | 195 |
| Хүүхдийн сүрьеэ | 40 | 19 |
| Флюр шинжилгээ | 16171 | 9144 |
| Түрхэцийн шинжилгээ | 1250 | 1183 |
| ЭМЧТ | 85 | 168 |
| G- хрерт | 193 | 156 |
| Туберкулины сорил тавьсан | 1355 | 1079 |
| Хавьтлын шинжилгээнд хамралт | /317-251 / 79,1% | 398 -320 80,1% |

- Эмчилгээ тасалсан 20 тохиолдлыг өдөр бүрээр бүртгэн мэдээллийн сан бүрдүүлж, 56 удаа дуудаж шалтгааныг тодруулан, тулгарч буй бэрхшээлийг арилган хамтран ажилласнаар 16 тохиолдлыг эмчилгээг үргэлжлүүлэн эмчилгээний амжилт сайжирсан.
- Амьдарч буй хаяг тодорхойгүй, ар гэр утас холбогдохгүй, ажлын газар тодорхойгүй 7 тохиолдлыг эмчилгээг таслахгүй, үргэлжлүүлэхэд хамтран ажиллах талаар дүүргийн цагдаагийн хэлтэст ЭМТ-өөс 1/594 албан тоот хүргүүлэн ажиллаж байна.
- “Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах” тухай ЭМТ-ийн даргын 2017.11.13-ны өдрийн А/105 тушаалын дагуу эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтний эмчилгээний асуудлыг шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөнийг 5 удаа хийж, 28 тохиолдлын эмчилгээ, хяналтыг шийдвэрлэсэн.

- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн богино хугацааны” стрим судалгааны 2 дахь шатны эмчилгээнд 3 өвчтөн хамруулан 24 сарын ОЭТС эмчилгээг 9 сар хийж, эмчилгээний дараах 36 сарын хяналтыг хийж байна.

**ДОТС ийн эмчилгээ хяналт**

| Шууд хяналтай богино хугацааны эмчилгээ хяналт | Тохиолдлын тоо 2017 он | 2018 оны эхний10 сар /тохиолдлын тоо/ |
|---|---|---|
| Диспансерын хяналтанд эм ууж байгаа | 129 | 161 |
| СКЭ хэвтэж гарч ирсэн өвчтөний тоо | 37 | 54 |
| ӨЭМТ-д дотс-ын эмчилгээг хяналттай хийгдэж байгаа өвчтөний тоо | 47 | 54 |
| СДИ гэртээ хүргүүлж эмчлэгдэж байгаа байгаа | 59 | 48 |
| ЭТС өдрийн эмчилгээний цэгт эмчилэгдэж байгаа | 52 | 31 |

**Эмчилгээний амжилт, үр дүн**

| № | Улирал | Шинэ тохиолдлын тоо | Сөрөгт шилжилт | Эмчилгээний амжилт |
|---|---|---|---|---|
| 1 | 2018 оны I улирал | 63 | 88,2% | 84,7% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | 2018 оны II улирал | 80 | 82,8% | 86,5% |
| 3 | 2018 оны III улирал | 34 | 88,4% | 90,9% |

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд чанартай үзүүлэхийн тулд дүүргийн эрүүл мэндийн салбарт ажиллагсадын тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах зорилтийн хүрээнд**

ЭМТ нь ХУД-ийн 14 хороо, 38 сургууль, 42 цэцэрлэг, 7 их дээд сургууль ДЗОУБ, ХУЭМТ, ХУДНЭ, МӨАУМХ, Ус сувгийн удирдах газрын Хан-уул салбарын 1, 2-р хэсэг, Түшигт хангай ХХК, Элемент ХХК, Эрдэнэсийн сан, Цэгээмаа, Цахиур төмөр, Энд эн, Шидэт рашаан, Буйлан нуур, Био- эмийн сан, Голден-Эра ХХК, Хороодын ахмадын зөвлөл, ХУД-ийн цагдаагийн 1, 2-р хэлтэс, ХУД-ийн “Тохижилт үйлчилгээ“ ХХК, “Эрүүл нүдэн” ЭХО ны эмнэлэг, “ДИ ЮУ ДИ” ХХК, “Хаппи Веритас” ХХК, “Хаган Богда” НҮТББ, “Good Neighbors”, Хүүхэд хөгжлийн төв, Ачлалт орчлон ТББ, Био-үйлдвэр, Баянсонгин, Догд, Марната сүм, Хүүхэд гэр бүл хөгжлийн төв, Гүнж төв, Тайваны хөгжлийн сан, Америк дахь монголчуудын нийгэмлэг, Гэгээрэл төв, Отгонтэнгэр шүдний эмнэлэг, Мон анир ТББ, SCH, like, TV9, МҮОНТ телевиз, КРКА, ЭНТО, Актавис, Гедеон Рихтер зэрэг байгууллагууд, мөн сайн санааны 902 туслагчтай тусламж үйлчилгээнийхээ чанар, хүртээмжийг сайжруулах иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа. . Нийт өрхийн эрүүл мэндийн төвд сайн дурын идэвхитэн **738** байгаа бөгөөд үүнээс өсвөр үеийн сургагч **429**, сайн санааны туслагч **120** ажиллаж байна.





Эрүүл мэндийн сайдын 2018 оны 07 сарын 20-ны өдрийн А/ 295 дугаар тушаалын хэрэгжилтыг хангах зорилгоор “Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын зохион байгуулах ажлын хэсгийг Хан- Уул эрүүл мэндийн 2018 оны төвийн даргын 2018 он 08 сарын 15-ны өдрийн А/76 тоот тушаалаар батлан ажлын төлөвлөгөө гарган ажиллаа.

1.“Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар”-ын аяны хүрээнд 2 буюу түүнээс дээш ерөнхий боловсролын сургууль хүүхэд нь сурдаг эмч, эмнэлэгийн ажилчдын судалгааг гарган 30 ажилтны хүүхдүүдэд хичээлийн хэрэглэл бэлдэж өглөө 2018 онд ажилчдын ниймгийн баталгааг хангах зорилгоор буцалтгүй тусламжинд 11 хүнд 1.800.000 төгрөг, 5 ажилтанд цалингийн урьдчилгааг 1-2 сараар, өндөр насны тэтгэвэрт гарсан 9 ажилтанд 5,427,502 төгрөг зарцуулсан байна. Хөдөлмөрийн дотоод журмын 8.2, 8,3 заалтын дагуу ажилчдын нийгмийн баталгааг хангах

зорилгоор тухайн байгууллагад тогтвор суурьшил, үр бүтээл, идэвхи санаачлагатай ажиллаж байгаа үр дүнгийн урамшуулал 194 ажилтанд 3.326.072, буцалтгүй тусламжийнтэтгэмж 11 ажилтанд 1.800.000 төгрөгний тэтгэмж олгов. Мөн амьдралын хүнд нөхцөлд амьдардаг, өрх толгойлсон 20 ажилтанд түлээ нүүрсний мөнгө олгох гэж байна.. Мөн ажилчдын хоолны нэмэгдлийг 1 өдрийн 3000, унааны нэмэгдлийг 1000 төгрөг болж нэмэгдүүлсэн. 195 ажилтанд хөдөлмөр хамгаалалын хувцас авахад 8.850.000 сувилагч нарт гутал зэрэг тус тус зарцуулсан байна

**Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагуудтай сургалт, уулзалт зохион байгуулж хамтран ажиллах зорилтийн хүрээнд**

МУ-ын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй Халдварт бус өвчнөөс сэргийлэх хөтөлбөр, Нийслэлийн засаг даргын 2006 оны 165 дугаар захирамж, ХУД-ийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хан-Уул Эрүүл Мэндийн төвийн даргын 2017 оны А/13 тоот тушаал зэрэг төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ажиллаж байна.

ХУД-ийн ЗДТГ-ын даргаар батлуулсан МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит Бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын 2 сарын аяны удирдамжийн дагуу ХУД-ийн ЗДТГ, Нийгмийн хэлтэс, ХУД-ийн БТСХ, ХУЭМТ хамтран 2 үе шаттайгаар зохион байгуулж, 1-р үе шатанд: дүүргийн хэмжээний төрийн албан байгууллагын ажилтан албан хаагч нарыг , 2-р үе шатанд хороод, ӨЭМТ-үүдээр дамжуулан иргэдийн хамрууллаа. Тус аяны хүрээнд хийгдсэн сорилын аян нь Биеийн бүтэц тодорхойлох аппарат ашиглан газар дээр нь хоолны хөтөлбөр зохиож зөвлөгөө өгснөөрөө онцлогтой байсан. Тус аяны хүрээнд иргэдэд зориулсан 6 төрлийн сурталчилгааны материал 600 ширхэг гарган дасгал хөдөлгөөнийг сурталчилан, аяны арга хэмжээний хулдаасан хэвлэл 4 ширхэгийг хэвлүүлэхэд нийт 1.228.000 төгрөгний санхүүжилтийг дүүргийн ЗДТГ-аас гаргасан.
Бие бялдрын сорилд ХУД-ийн ЗДТГ-ын харъяа албан байгууллагуудаас нийт 480 хүн хамрагдаж 89% тай явагдсан байна.








ХУД-ийн Эрүүл мэндийн төвийн эмч ажилчдаас бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2018 оны 03 сарын 05-наас 03 сарын 09-ны хооронд хуваарь гарган ажилчдын эмч, хоол зүйчтэй хамтран авсан. Нийт ажилчдын 90,4% нь буюу 190 хүн сорилд хамрагдсан байна. Тус аяныг идэвхжүүлж үр дүнтэй зохион байгуулах

зорилгоор Биеийн бүтэц тодорхойлох аппаратаар тодорхойлж хооллолт болон дасгал хөдөлгөөнөөр хичээллэх зөвлөгөө өгч ажиллалаа.






Аяны үйл ажиллагааг сурталчилах зорилгоор нээлтийн үйл ажиллагааг 2018 оны 03 сарын 15-нд ХУЭМТ-ийн гадаа талбайд зохион байгууллаа. Нээлтийн арга хэмжээнд Олимпус жем оролцож спиннинг, аэробик дасгалын үзүүлэх тоглолт хийж иргэдэд идэвхтэй дасгал хөдөлгөөний сурталчилсан. Нээлтийн үйл ажиллагааг нээж Засаг даргын зөвлөх Ч. Баторгил нээж үг хэллээ. ТВ-5, NTB, MNB, телевизүүд ирж оролцлоо.







Сорилын аяныг сурталчилах зорилгоор Биеийн тамир, спортыг газартай хамтран MNB спортын мэдээгээр сорил авах аргачлалын талаар мэдээлэл хийж ажилласан. Сорилын аяны 2-р үе буюу 4 сарын 05-аас 5 сарын 05-ны хооронд Хороод, ӨЭМТ-үүд, ЕБС, СӨБ байгууллагуудыг хамруулан ажилласан ба 82 байгууллагын сорил авах мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан






Сорилын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 82 байгууллагын сорил авах цэгтэй танилцаж, сорил үнэн зөв авч байгаа эсэх, түүнд тавих хяналтыг бий болгох зорилгоор ДЭМЖЛЭГ ХЯНАЛТ зохион байгуулсан.








ХУД-ийн нийт иргэдийн 10% -ийг сорилд хамруулах зорилт тавин ажилласнаас 20.000 хүн буюу 13,1% -ийг хамруулж тавьсан зорилтоо 3,1%-иар давуулан биелүүлж ажиллаа.

2017 онд ХУД-ийн хэмжээнд 3-64 насны нийт хүн амаас 14202 хүн Бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан бол 2018 онд 20032 хүн хамрагдсан байна.Хамрагдалт урьд оноосоо 18%-иар өндөр байна






**<u>Сургалт сурталчилгаа, тэмцээн , өдөрлөгүүд</u>**

ХУЭМТ-ийн эмэгтэйчүүд, мэдрэл, дотоод шүүрэл, зүрх судасны кабинетууд, 16 хорооны өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран дасгал хөдөлгөөн хийх шаардлагатай иргэдэд зөвлөгөө өгч, биеийн онцлогт тохирсон дасгал зааж, ЭМТ-дээр 5 хоног дасгалд хамрагдаад цаашлаад үргэлжлүүлэн ӨЭМТ дээрээ дасгалдаа хамрагдан ажиллаж байна. Үүнд нийт 320 хүн хамрагдаж давтан тоогоор 1.600 удаа чийрэгжүүлэх дасгалд хамрагдсан байна

“Улаанбаатар Марафон-2018” цомын хүрээнд ХУД-ийн хэмжээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулж ЭМТ болон ӨЭМТ-үүдээс 84 хүн хамрагдсан байна.





Цомын хүрээнд ХУЭМТ-ийн эмч ажилчдын дунд Дартсын спортын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан. Тус тэмцээнд 5 тасгийн 40 хүн хамрагдаж аваргуудаа шалгаруулсан байна.






Цомыг хуваарь ёсоор ХУД-ийн цагдаагийн 1-р хэлтэст хүлээлгэн өглөө.

Биеийн тамир спортын газрын ажил танилцуулах өдөрлөгт Хан-Уул Эрүүл мэндийн төвийн Сорилын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор эмч нар хамтран иргэдэд даралт үзэж, дасгал хөдөлгөөний сурталчилгаа хийж, биеийн бүтэц тодорхойлох аппаратаар үзлэг хийж зөвлөгөө өглөө. Үүнд: 3 эмч, 2 нийгмийн ажилтан, 1 арга зүйч ажиллалаа.

1. Артерийн даралт – 350 хүн
2. Сурталчилгаа – 500 хүн
3. Биеийн бүтэц тодорхойлох аппаратаар – 50 хүнд үйлчилж зөвлөгөө өглөө.







ХУД-ийн Засаг даргын нэрэмжит 5 төрөлт тэмцээнд ХУЭМТ-ийн эмч ажилдаас 43 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдэн оролцсон. Эмэгтэй Волейболын төрөлд хүрнл медаль, Багийн нийлбэр дүнгээр 24 багаас 6-р байрт шалгарсан.





ХУЭМТ-ийн эмч ажилчдыг чийрэгжүүлэх зорилгоор  бие бялдраа чийрэгжүүлэх зорилгоор зуны 3 сарын турш өглөөний дасгалыг хийж, 10 сараас эхлэн жин хасах аян зарлан өглөө ажил эхлэхээс өмнө 7.30-8.20 цагийн хооронд тогтмол дасгал хийж хэвшээд байна.






23. Эмч ажилчдыг чийрэгжүүлэх зорилгоор ХУЭМТ-ийн даргын нэрэмжит “Идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аян зохион байгуулж ажилласан. Тус аяны хүрээнд: Эмч ажилчдын чөлөөт цагийг зөв өнгөрөөх, хамт олны хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Манзушир хийд-Цэцээ гүн гэсэн чиглэлээр алхалт, Зайсангийн ам-Цэцээ гүн гэсэн чиглэлээр 2 удаа алхалт хийсэн.






ХУДЗДТГ, ӨЭМТ-үүдтэй хамтран Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Авто машингүй” өдөрөөр талбай дээр сургалт сурталчилгаа хийсэн.







2017 оноос хойш Хан-Уул дүүргийн усан спорт сургалтын төв, Олимпус фитнесс төвтэй хамтран ажиллах 2 талын гэрээ байгуулан 2018 оны байдлаар нийт 30 эмч ажилчид хамрагдаад байна.


БАТЛАВ
УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.БАЗАРЗАЯА

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Э.БОДЬЦЭЦЭГ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

2.ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ


БАТЛАВ.
УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Б.БАЗАРЗАЯА
2017 оны ....сарын .... –ний өдөр

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Э.БОДЬЦЭЦЭГ
2017 оны ....сарын .... –ний өдөр

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2017 оны ... сарын ... ний өдөр № Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Хан-Уул Усан спорт сургалтын төвийг төлөөлж Менежер Б.Болдболор /цаашид"А"тал гэх/, нөгөө талаас Хан-Уул Эрүүл Мэндийн төвийн дарга Э.Бодьцэцэг /цаашид"Б"тал гэх/ нар усан сэлэлтийн сургалтанд хамруулах, сургалтын орчинг хангаж ажиллахаар хоёр тал харилцан тохиролцож байгуулав.

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Эмч ажилчдын дунд Шагай наадгайн тэмцээнийг зохион байгуулллаа. Эрүүл залуус-Эрүүл ажлын байр уриатай зохион байгуулагдсан Ширээний шагайн наадгайн тэмцээнийг Хан-Уул Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвийн 10 багийн 70 гаруй эмч ажилчид хурц мэргэнээ сорин өрсөлдлөө. Нийт багийн төрөлд 3 байр эзлүүлэн, ганцаарчилсан төрөлд 3 байр эзлүүлэн шалгаруулла.










“Мөнгөн Улаанбаатар-2018” цасны баярын арга хэмжээ, “DAWA-2018” өртөөт олон улсын марафонд ХУЭМТ-өөс баг тамирчид амжилттай оролцсон







2018.11.17нд ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, ХАН-УУЛ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ХОРОО хамтран "**ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР**" сургалт өдөрлөгийг ХУД-ийн ЗДТГ-ын харьяа хэлтэс албадын 150 гаруй ажилчдад амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгт ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйл болох Архи, Тамхины хэрэглээ, стресс, зөв хооллолт, дасгал хөдөлгөөний талаар сургалт хийж, эрүүл хүнсээр үзэсгэлэн, эрүүл хоолны амталгаа гаргаж ажлын байрны дасгалын CD, гарын авлага гаргаж 30 гаруй албан байгууллага авч ажлын байрандаа дасгал хөдөлгөөн хийх боломжоор хангагдлаа.






2017 оноос хойш ХУД-ийн БТСХ гэрээ хийн Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч ажилчдыг 14 хоногт 1 удаа спорт заалаар хանган тогтмол хамрагдаж байна. ӨЭМТ-дийн спорт хамтлагийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор ХУД-ийн Спорт хамтлагуудын дунд 3 төрөлт спортын арга хэмжээ зохион байгууллаа. 16 хорооноос 11 хороо хамрагдсан.






ХУД-ийн БТС хороо, ХУЭМТ хамтран Дүүргийн 16 хорооны иргэний танхимыг түшиглэн иргэдэд өдөр бүр дасгал заах сайн дундын 32 ахмадад Сайн дурын багш бэлтгэх сургалтыг 21 хоногийн хугацаатай зохион байгууллаа.






**Хороодын өрхийн эмнэлгүүдийн үйлчилгээний стандартыг шинэ түвшинд гаргаж, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэхэд анхаарч материаллаг бааз, хүний нөөцийн ур чадвар, боловсон хүчний орон тоо, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд**

- . Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний MNS:5292-2017 стандартанд заагдсан тусламж, үйлчилгээний жагсаалтын дагуу дараах тусламж үйлчилгээг үзүүлж байна Үүнд. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр 10, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 7 нэр төрлийн тусламж үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэж байна ӨЭМТ-ийн хэмжээнд эмчилгээ оношлогооны 17 удирдамж 27 стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол мөрдөн ажиллаж байна.

Магадлан итгэмжлэлд орсон ӨЭМТ-6, Магадлан итгэмжлэлд орсон боловч батламжаа аваагүй, үнэлгээгээ хийлгэсэн-3, Магадлан итгэмжлэлд ороогүй-6 ӨЭМТ байна. . 2018 онд магадлан итгэмжлэгдэж батламж авсан Тэрмэстий, Манал-Үйлс, Уясах, Аяут, Амгалан Өрх, Амин тус, Мэндсаруул Өрх, Энхбуянтманал ӨЭМТ-үүд, стандартын дагуу багц тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлж 2018 оны 8 дугаар сараас эрүүл мэндийн даатгалаас нэмэлт санхүүжилт авч эхэлсэн

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд“ Хан-Уул дүүргийн 10, 11,14-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих төслийг хэрэгжүүлэхээр болсон.Өрхийн эрүүл мэндийн төвдүүд хэрэгжиж буй эмнэл зүйн стандарт, удирдамжуудыг эмч, сувилагч нарт мөрдүүлэн, шинээр ажилд орсон эмч, сувилагчид Өрхийн эрүүл мэндийн төвийн стандарт MNS 5292MNS 5292:2017-г багцлан танилцуулж мөрдүүлэн ажиллаж байна.

Дүүргийн 15 өрхийн эрүүл мэндийн төвд Өрхийн эмч - 76, сувилагч – 54, ЭМНА-15, туслах ажилтан-53 тус тус ажиллаж байна. ӨАУАхлах зэрэгтэй эмч нар-9, АУхааны магистр-4 ,Сувилахуйн ахлах зэрэгтэй сувилагч-8 тус тус байна. Эмч мэргэжилтнүүдийн мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр дараах сургалтуудад хамруулсан байна. Үүнд:

- Лабораторийн мэргэшүүлэх 1 сарын сургалтанд 4 хүнийг
- Сэргээн засах тусламж үйлчилгээний мэргэшүүлэх 3 сарын сургалтанд 3 хүнийг

дархлаажуулалтын мэргэжил олгох 3 сарын курст 1 сувилагчийг тус тус хамруулсан ӨЭМТ-үүд ажлын байрны сургалтыг хуваарийн дагуу явуулж эмч нар 18 удаагийн сургалтанд, сувилагч нар 12 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 580 эмч, сувилагч, ажилтнууд хамрагдсан.Багц цагийн сургалтуудад 16 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 325 эмч 45 кредит цагийн сургалтанд, 6 нэр төрлийн сургалтанд давхардсан тоогоор 125 сувилагч 22,5 кредит цагийн сургалтанд тус тус хамрагдсан байна.

Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын хүрээнд 2018 оны 03 дугаар сарын 1-ны өдөр 2017 оны гурвалсан гэрээгээр А /Бүрэн хангалттай/ үнэлгээ авч эхний 3 байранд шалгарсан Уясах, Мэндсаруул-өрх, Энхбуянт манал ӨЭМТ-үүд бусад ӨЭМТ-үүддээ үзүүлэх сургуулийг амжилттай зохион байгууллаа





Тусламж үйлчилгээний нэр төрлийг олшруулах хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2018 онд шинээр дараах багаж материал, тоног төхөөрөмжийг улсын төсвөөс болон хандив тусламжаар авч үйл ажиллагаандаа ашиглаж байна: Үүнд:

- Зөөврийн кварц-4ш
- Пульсоксиметр -8 /төсвөөс/
- Автомат даралтны аппарат- 62ш / ОНОМ сангаас/
- Бумба – 8 ком /төсвөөс/
- Элэгний В,С-вирусын түргэвчилсэн тест – 23000ш /төсвөөс/
- ХДХВ/ДОХ түргэвчилсэн тест –900ш/төсвөөс/
- Тэмбүүгийн түргэвчилсэн тест –1100ш/төсвөөс/, Дэмжих сангийн санхүүжилтээр -260ш
- Сахарын тест - 1600ш /төсвөөс
- Шээсний шинжилгээний ариун сав - 2600ш
- Утлаганы аппарат – 7ш / лапша брэндээс хандиваар/
- Компьютер - 6ш /УИХ-ын гишүүн Л.Болд хандив/
- Эмэгтэйчүүдийн толь –2800ш төсвөөс
- Тавиур шил – 2800ш /төсвөөс
- Өндөг цоологч- 23000ш /төсвөөс
- Хүчилтөрөгчийн коктейлийн аппарат-1 /УИХ гишүүн Л.Болд хандив/





